



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2, 6.1, 6.2.2, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн хохирол барагдуулах зорилгоор ТОГТООХ нь:

1. Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, зам тээврийн осолд өртсөний улмаас цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 32,000,000.00 (гучин хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан тээврийн хэрэгслийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Иргэн Э.Энхбатын хохирол барагдуулах хүсэлтээр, Тоёота Ландкрузер 100 маркийн, 22-41 УНИ улсын дугаартай, UZJ1000021219 арлын дугаартай, 1998 онд үйлдвэрлэсэн, 2006 онд импортлогдсон автомашиныг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэлж, Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Тээврийн хэрэгслийг комисс томилон хүлээлцэх;


3.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСҮЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001738

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
209 дугаар тогтоолын хавсралт



Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
				(төгрөгөөр)		
1	Тоёота Ландкрузер 100, 26-86 УБЕ, суудлын, арал: JT3HT0517Y0078271	2000/2008	193199	32,000,000.00	32,000,000.00	0
	Дүн	-	-	(гучин хоёр сая)		